

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/240/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаангом хот 2022 он</p>	<p>Увс аймаг дахь Төрийн аудитын газар, Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn Аудитын менежер: М.Бат-Амгалан Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn Аудитор: Ч.Мөнхтогтох Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА
Ч.ЧИМЭД ТАНАА

**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.03.15 № УВА-2022/240/УА-СГА-ТЧЗ
танай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБООС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР


Ч.ЧИМЭД ТАНАА

0200200180

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	6
3.4 Материаллаг байдал.....	7
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	7
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	9
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	8
3.8 Аудитын гол асуудал.....	8
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	8
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	9
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	9
4. Аудитын илрүүлэлт	9
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	10

2.2.Аудит хийсэн Санхүүгийн үр дүнгийн тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	385,200,438.00	268,366,192.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,100,438.00	9,866,192.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,100,438.00	9,866,192.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,100,438.00	9,866,192.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,100,438.00	9,866,192.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	381,100,000.00	258,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	381,100,000.00	258,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	381,100,000.00	258,500,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	385,200,438.00	268,366,192.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,200,438.00	268,366,192.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	353,273,350.00	256,214,379.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	353,273,350.00	256,214,379.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	353,273,350.00	256,214,379.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,927,088.00	12,151,813.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захиралчдад олгох татаас, санхүүжилт	31,927,088.00	12,151,813.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,927,088.00	12,151,813.00

2.3 Аудит хийсэн Мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГ ЫН ДҮН (I)	385,200,438.00	268,366,192.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,100,438.00	9,866,192.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,100,438.00	9,866,192.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,100,438.00	9,866,192.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санху үжих	4,100,438.00	9,866,192.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГ О	381,100,000.00	258,500,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	381,100,000.00	258,500,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /ор он нутгийн төсөвт байгууллага/	381,100,000.00	258,500,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН Д ҮН	385,200,438.00	268,366,192.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	385,200,438.00	268,366,192.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДА Л	353,273,350.00	256,214,379.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээн ий төлбөр, хураамж	353,273,350.00	256,214,379.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг аж ил үйлчилгээний төлбөр хураамж	353,273,350.00	256,214,379.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,927,088.00	12,151,813.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захир агчдад олгох татаас, санхүүжилт	31,927,088.00	12,151,813.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,927,088.00	12,151,813.00

2.5 Аудит хийсэн Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	ЗГСУМС гүйцэтгэл	Гүйцэтгэл зөрүү
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	258,500,000.00	256,214,379.00	256,214,379.00	0.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	258,500,000.00	256,214,379.00	256,214,379.00	0.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	258,500,000.00	256,214,379.00	256,214,379.00	0.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	258,500,000.00	256,214,379.00	256,214,379.00	0.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	258,500,000.00	256,214,379.00	256,214,379.00	0.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	258,500,000.00	256,214,379.00	268,366,192.00	-12,151,813.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0	0	258,500,000.00	-258,500,000.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	0	0	258,500,000.00	-258,500,000.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	258,500,000.00	246,348,187.00	0	246,348,187.00
320001	Орон нутгийн төсвөөс	258,500,000.00	246,348,187.00	0	246,348,187.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	0	9,866,192.00	9,866,192.00	0.00
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	9,866,192.00	9,866,192.00	0.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 7/384 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Увс аймгийн Байгаль хамгаалах сан нь Эдийн засгийн өсөлт, нийгмийн хөгжлийн хандлагыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байхад чиглүүлж хамгаалах, байгалийн нөөцийн баялгийг зохистой ашиглах, жам ёсоор нөхөн сэргэх боломжийг бүрдүүлэх, байгальд ээлтэй тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх замаар хүрээлэн байгаа орчны тогтвортой байдлыг хадгалах чиглэлээр төсөл арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагатай гэж үзэж шалгахад дотоод аудитын чиг үүрэг бүхий байгууллагуудаас тайлант онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Байгаль хамгаалах сан 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 268,366.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,683.7 мянган төгрөгөөр тооцсон, гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар тооцож 2,146.9 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх балансыг дуусгавар болгосон байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан авлагын данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Бараа материал	0.0	0.0	0.0
Үндсэн хөрөнгө	0.0	0.0	0.0
Нийт хөрөнгө	0.0	0.0	0.0
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	0.0	0.0	0.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	0.0	0.0	0.0

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл байхгүй байна.

Дансны өглөг, авлага байхгүй байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 116,834.2 мянган төгрөгөөр буюу 30.0 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 116,834.2 мянган төгрөгөөр буюу 30.0 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бусдаар гүйцэтгүүлэх бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2021 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтыг Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 3/04 дүгээр тогтоолоор 175,000.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Увс аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 8 дугаар сарын 06-ны өдрийн 5/01 дүгээр тогтоолоор тодотгол хийж зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 83,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 258,500.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн хэмжээг санхүүжүүлэхээр 258,500.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс төлөвлөж баталжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 258,500.0 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогоос 9,866.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсөл, арга хэмжээнд 256,214.3 мянган төгрөгийг зарцуулж, 12,151.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 256,214.3 мянган төгрөг буюу 99.1 хувьтай байна.

Цаг агаарт зориудаар нөлөөлж, хур тунадсыг нэмэгдүүлэх зардалд 20,000.0 мянга, нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөц хамгааллын арга хэмжээг хэрэгжүүлэх зардалд 24,625.0 мянга, Зэрлэг ан амьтдад зориулж биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх зардалд 10,000.0 мянга, Ойн аж ахуйн арга хэмжээг зохион байгуулах, ойн үрийн талбай тусгаарлах, байгалийн сэргэн ургалтад туслах ажлын зардалд 14,900.0 мянга, Ө.Бадрахын цэцэрлэгт хүрээлэнд жуулчдад үйлчлэх худалдааны орчин бүрдүүлэх, ногоон байгууламж нэмэгдүүлэх зардалд 136,236.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Онцолсон болон бусад асуудал байхгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгадаг. Увс аймгийн Байгаль хамгаалах сангийн хувьд shilendans.gov.mn сайтад бие даасан цэсгүй ба шаардлагатай мэдээллээ төсвийн ерөнхийлөн захирагчийн сайтад байршуулдаг байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн акт тогтоосон. Энэхүү төлбөрийн акт нь Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхэд хянагдаж байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар зөрчил илрээгүй болно.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс								
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
1	Аймгийн Байгаль хамгаалах сан											
ДҮН												

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР /Ч.МӨНХТОГТОХ/



2022 оны 03 сарын 15-ны өдөр